

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 04 дүгээр сарын мэдээлэл

2022.04.25.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 7 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор сумын ИТХ-ын байгууллага сумын ЗДТГ, төрийн бусад байгууллагын удирдлагуудтай хамтран ажиллах журмыг 5 зүйл 34 заалттайгаар,

-7 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолоор сумын хэмжээнд мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 17 чиглэлээр,

-7 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолоор “Хоршоо хөгжүүлэх сан”-д зээлийн хүсэлт ирүүлсэн хоршоо болон ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий Зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр,

-7 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолоор “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн Хяналтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр,

-7 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолоор “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн зээлийн хүүгийн орлогын хувийг зарцуулах тухай тус тус шийдвэрлэв.

Сумын Засаг даргын 2022 оны А/36 дугаар захирамжаар сумын ЕБС-д “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГ” –ийг сургуулийн захирлаар ахлуулан нарийн бичгийг Нийгмийн ажилтнаар томилж, 29 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томиллоо.

Сумын Засаг даргын захирамжаар 2,980000 төгрөгийн техник тоног төхөөрөмжийг сумын УЦУОШ-ний төвийн “Дарьганга өртөө”-ний байгууллагад өгсөн.

-Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс операторч 4 дүгээр сард 20 иргэнд 5 төрлийн үйлчилгээг үзүүлээд байна.

-Сумын Багийн Засаг дарга нар, Нийгмийн даатгалын байцаагчтай хамтран хөдөөгийн багт ажиллаж байна. Үүнд: а/. Цэргийн зарлан дуудах хуудас тараах

б/. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах

в/. Цаг үеийн бусад мэдээллийг өгөх

г/. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чиглэлээр үйлчилгээ явуулж байна.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

-Сумын Засаг даргын 2022 оны А/44 дүгээр захирамжаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарих ажлаар 4 группэд 11 хүн ажиллаж байна. Вакцины явцын талаар: -134 хот айлын 6700 үхэрт вакцин тарьсан нь 26,6 % тай байгаа.

-4 р сард сумын 1 дүгээр багийн 1 суурьт 15 үхэр шүлхий өвчнөөр өвчилсөн бөгөөд үхэж хорогдоогүй, шинж тэмдэг нь арилсан байдалтай, хязгаарлалт болон хорио цээрийн дэглэмтэй ажиллаж байгаа.

-Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2022.04.22 ны өдөр 3 байршилд газрын цахим дуудлага худалдаа зохион байгууллаа.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ахлах ангийн суралцагчдын дунд **“Мөнгөнд ухаалаг хандаж, ирээдүйгээ өөрсдөө бүтээ”** сэдэвт сургалтыг Дарьганга сумын Төрийн банкны хамт олон, Албан бус насан туршийн боловсролын багш нар хамтран зохион байгуулсан.

2022 оны 04 сарын 02-ны өдөр Баруун-Урт хотноо зохион байгуулагдсан монгол хэл бичгийн эрхийн шалгалтад 12 “а” ангийн суралцагчид маань аймгийн дунджаас 82.8 оноогоор илүү шалгагдсан.

2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр БСУГ-ын ажлын хэсэг суманд ажиллаж Багш нарын хичээл дээр сууж, бичиг баримттай танилцаж, Залуу багш нар болон элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэж буй багш нартай уулзаж заавар зөвлөмж чиглүүлэг өглөө.

2022 оны 4- сарын 18-22-ны хооронд “САЙН БАГШИЙН- САЙН ТЕХНОЛОГИ” ур чадварын уралдааны эхний шат болон 2 дугаар шатанд Байгалийн ухааны Заах аргын нэгдлээс химийн багш нэг, Нийгмийн ухааны Заах аргын нэгдлээс монгол хэлний багш нэг , Багийн Заах аргын нэгдлээс бага ангийн багш нэг нар шалгарлаа.

“Хаврын баяр-2022” урлагын бага наадмыг бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулж урлагаар тэргүүний ангиудыг шалгаруулсан.

Зүүн бүсийн "ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ӨСВӨРИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2022" тэмцээн Дорноговь аймагт амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд 5 аймгийн 8-18 насны 126 тамирчид, хүч, авхаалж самбаагаа сорьж өрсөлдсөнөөс Дарьганга сумын ерөнхий боловсролын сургуулийн 7 сурагчид амжилттай оролцож аймгаараа III байрт шалгарсан.

2022 оны 04 дугаар сарын 09-ны өдөр улсын төрөлжсөн олимпиадын Хоёрын даваанд нийт 9 хичээлээр амжилттай оролцож сумын дүнгээр түүхээр хүрэл медаль, химийн хичээлээр 4 дүгээр байр, Нийгмийн ухааны хичээлээр 4 дүгээр байрт тус тус шалгарсан.

2022 оны 4 сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээнд сумаас оролцсон тамирчид 2 мөнгөн медаль, нэг хүрэл медаль хүртлээ.

Дэлхийн номын өдрийг угтаж 2022.04.20-ны өдөр "Аз жаргалтай суралцъя" номын өдөрлөгийг Соёлын төв, сургуулийн номын санчид хамтран амжилттай зохион байгуулж дунд,ахлах ангийн сурагчдад "Ном уншихын ач холбогдол давуу тал, "Илтгэх урлаг гэж юу вэ? ямар ач холбогдолтой болох талаар мэдээлэл зөвлөмжийг хүргэн хамтран ярилцаж, танин мэдэхүйн "Аха" тэмцээн зохион байгууллаа.

- Бага ангийн сурагчдад "Ном уншихын ач холбогдол давуу талын талаар мэдээлэл зөвлөмж хүргэн, Сургамжит өгүүллэг, Монгол ардын үлгэр уншиж өгөн юу ойлгож авсан, юу нь сургамжтай байсан талаар яриа өрнүүлж, танин мэдэхүйн "Аха" тэмцээнийг зохион байгуулсан.

-Номын үзэсгэлэн гаргасныг хүүхэд багачууд сонирхон үзлээ.

-Сургуульд “Явуулын номын сан”-г ажиллуулж байна.

ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн охидын дунд **“ОХИДЫН ЗӨВЛӨГӨӨН”**-ийг 4 өртөөгөөр зохион байгуулж, төгсгөлд нь мэдлэгийг бататгах зорилгоор 3 агуулгаар хэлэлцүүлэг зохион байгуулж, Ахмад эмч, эх баригч Д.Дариймаа урилгаар оролцож **“ОХИД БҮХЭН ҮЗЭСГЭЛЭНТЭЙ”** чөлөөт ярилцлагаар охидод өөрийгөө хайрлах, эмэгтэй хүний эрхэм нандин байдал, эрүүл ахуйн зөвлөмж зөвлөгөөг өгсөн.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

-Сумын ЗДТГ-аас төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр ковидын дараах хор уршгийг арилгах зорилгоор ажилтан албан хаагчдыг УБ хотын нэгдүгээр эмнэлэгт шинжилгээ, үзлэгт хамруулж, байгууллагаас 3 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэв.

-“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ ДАРЬГАНГАЧУУД” аяны хүрээнд өглөө бүр иргэд, төрийн албан хаагчид 6 цагт Соёлын төвд цугларч дасгал хийж хэвшээд байна. Өглөө бүр тогтмол 30 аас дээш хүн идэвхтэй хөдөлгөөн хийж байгаа. Мөн энэ дасгал хөдөлгөөний цагт багтаан цаг үеийн мэдээлэл хийх ажлыг ЗДТГ-аас хариуцан зохион байгуулж байна. Энэ аяны хүрээнд ЗДТГ, Эмэгтэйчүүдийн зөвлөл ТББ хариуцан гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа.

-Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “ЭМЧ НЭГ ӨДӨР” үйл ажиллагааг сумын Соёлын төвд 9 өртөөгөөр зохион байгуулж 125 иргэнд сурталчилгаа үйлчилгээ үзүүллээ. Энэ үеэр мобайл технологийг ашиглан ЭХО оношилгоо 45 хүнд , Зүрхний Цахилгаан Бичлэгийг 55 хүнд , Элэгний В вируст илрүүлэг шинжилгээг 25 хийж, “Элэг бүтэн монгол хөтөлбөрийн хүрээнд” элэгний хөтөч нар 55 иргэнд ухуулга хийж, гарын авлагаа тараалаа. Эмчилгээний хоолны үзэсгэлэн гаргаж, сурталчилсан.

-Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийн сарын аяны хүрээнд 30 иргэнийг вакцинд хамрууллаа.

-УБ хотын Шүдний мэргэжлийн эмч суманд ажиллаж 180 иргэнд үйлчилгээ үзүүлж, Цэцэрлэгийн хүүхдүүдэд үнэгүй фторт түрхлэг хийсэн.

Эмчийн баярыг тохиолдуулан “Энэрэлийн уянга” сэдэвт эмч, ажилчдын бүрэлдэхүүнтэй урлагийн тоглолтыг бэлтгэн сумын иргэдэд үзүүлсэн.

Тав. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг “АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН СОЁЛЫГ ХАМТДАА ТӨЛӨВШҮҮЛЬЕ” уриан дор зохион байгуулж байгууллагуудын зөвлөлийн дарга нар цахим сургалтад хамрагдаж, сарын аяны төлөвлөгөө удирдамжаа батлуулан эхний ээлжинд ЕБС, Цэцэрлэгийн байгууллагууд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022.04.23 ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Үүнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх сургууль, цэцэрлэг, дотуур байрын өдөр тутмын үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчид, иргэд, олон нийтэд сурталчлан таниулан, түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор а/. Ажлын байхрны дасгал б/. Ажлын байрны дүрэмт хувцасны үзүүлбэр в/. Хоол үйлдвэрлэлийн үзэсгэлэн г/. Сургалтын хэрэглэгдэхүүний үзэсгэлэн д/. Амьд цэцэгсийн үзэсгэлэн зэргийг тус тус зохион байгууллаа.

Зургаа: Байгаль орчны чиглэлээр.

-Аймгийн БОАЖГ-аас хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж 3 ширхэг үлээгч аппаратыг ЗДТГ-т өгсөн.

-2022.04.18 нд 2 сумын газар нутгийг хамарсан хээрийн түймэр гарч, хиймэл дагуулын урьдчилсан мэдээгээр 40969 га талбай шатсанаас сумын нутагт 1761 га талбай шатсан нь тогтоогдоод байна. Түймэрт 6 автомашин, 39 албан хаагч дайлчагдан 130 л бензин, 330 л түлш зарцуулсан. Хохирол тогтоогдоогүй байна.

-2022 онд “Эх дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан ЕБС-ийн бага дунд нийлсэн 9 ангийн 200 гаруй сурагчдад “Хог хаягдал болон гялгар уутны сөрөг нөлөө”, түүнийг багасгахад хүүхэд багачуудын байгалиа хайрлан хамгаалах хандлага, ухамсар, сэтгэлээ, оролцоо чухал болохыг..., Мөн Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд модны нэр төрөл, тарих арга, усалгаа арчилгаа, хашаа хамгаалалт, Мод тарихын ач ходбогдол түүний үр шим, давуу талыг сурталчилан таниулахыг зорьж анги тус бүрт нь сургалт хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.

Сумын хэмжээнд “Нийтийн их цэвэрлэгээ”-г зохион байгуулж 300 гаруй хүн ажиллалаа. Нийт 150 л түлш зарцуулж 10 тн хогийг түүж цэвэрлэн нэгдсэн цэгт асгалаа.

- Сумын ногоон байгууламжийн хашаа хашлага муудсан тул хадаж, гагнах ажлыг зохион байгууллаа. УБ хотын “БИОРЕСУРС ХХК”-тай 7000 мод тарих контрактын гэрээ байгууллаа.

- **Саарал чонын нөөцын судалгаа**

- Саарал чонын тоо толгой, үүрийг тогтоох зорилготой саарал чонын тандалт судалгааны ажлыг ТХГН болох Молцог элсэнд ажиглалт хийн нутгийн ард иргэдээс судалгаа аван ажиллахад дараахь газруудад чонын үүр бүртгэгдлээ. Үүнд: Овоот- 1, Гурван өндөр-2 гэх цэгт чонын мөр бүртгэгдсэн.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН: МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР